



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.04.22

№

473

танай

-Ы №

-Т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т
Д.АЮУРБУНЬ ТАНАА

Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг албан шаардлага, зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 28- хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ж.ГАНБААТАР

232530473

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: Oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Ариунаа Утас: 99195208 Аудитор: Ц.Хатанболд Утас: 91117325 Аудитор: Х.Баярбаатар Утас: 99058696 Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан	5
2.1 аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. АУДИТЫН ТАЙЛАН	9
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	9
3.1.1 Аудит хийсэн үндэслэл	9
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ	9
3.1.3 Аудитын арга зүй	9
3.1.4 Материаллаг байдлын түвшин	9
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	9
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж	10
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн	10
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	10
3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	10
3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	10
3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	11
3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	11
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	12
4.2 АВЛАГА	13
4.3 УРЬДЧИЛГАА	14
4.4 БАРАА МАТЕРИАЛ.....	15
4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ.....	16
4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16
4.7 ӨР ТӨЛБӨР	17
4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	18
4.9 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..	18
4.11 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ	21
4. 10 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	22
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	23
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ	23
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОХНСЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.04.22

№

772

танай

-ны №

-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.АЮУРБУНЬ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдалд болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлан онд 2,996.4 сая төгрөгийн үнэ бүхий авто тээврийн хэрэгсэл нэмэгдсэний 1,212.3 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслөөр ирсэн 12 ширхэг трактор байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслөөр хэрэгжсэн 658.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 2025 онд бүртгэлд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Хэрлэн сумын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ Багц-1, Багц-2-оор хэрэгжсэн 29,804.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг улсын комисс хүлээн авч, аймгийн Хэнтий-Ус ХХК-ны данс бүртгэлд тусгуулахаар ОНӨГ-аас шийдвэрлэсэн боловч тус компани бүртгэж аваагүй байна.

Аудитын гол асуудал

Дамжуулан зээлдүүлэх гэрээний урт хугацаат зээлийн төлбөрт 2022 онд 799.6 сая төгрөг, 2023 онд 725.7 сая төгрөг, 2024 онд 536.2 сая төгрөг нийт 2,061.5

232520472

сая төгрөгийг төлсөн боловч зээлийн төлбөр гэрээнд заасан хуваарийн дагуу хийгдээгүй байна.

Орон нутгийн өмчит байгууллагууд 2024 онд 20,731.8 сая төгрөгийн орлого олж, 19,507.4 сая төгрөгийн зардал гаргаж, 1,224.4 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч 7 байгууллага 119.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 90.7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэж, Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн боловч дүгнэгдэж ирээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		54,073,843.20	55,506,433.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	27,457,760.20	37,327,094.00
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	8,733,547.00	7,464,608.50
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	485,918.10	952,144.40
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	17,062,194.80	9,315,525.90
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	132,423.00	243,936.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	202,000.00	203,125.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		171,946,296.00	199,550,415.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	171,946,296.00	199,550,415.90
39200	Биет хөрөнгө		156,900,224.60	180,134,757.20
39300	Биет бус хөрөнгө	13	15,046,071.30	19,415,658.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		226,020,139.10	255,056,849.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		35,932,051.20	42,137,643.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	23,152,948.90	29,716,592.10
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	293,333.00	221,804.60
41300	Өглөг	17а, 17б	14,519,727.00	9,353,331.50
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	8,339,888.80	20,141,456.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,779,102.30	12,421,051.00
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	12,779,102.30	12,421,051.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		190,088,087.90	212,919,206.50
51	Засгийн газрын хувь оролцоо		190,088,087.90	212,919,206.50
51100	Засгийн газрын оруулсан капитал		32,546,178.30	32,579,626.30
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		2,006,893.50	2,022,060.10
51200	Хуримтлагдсан үр дүн		140,128,520.40	162,912,967.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,406,495.70	15,404,552.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		226,020,139.10	255,056,849.60

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		206,565,912.80	158,887,383.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО		28,822,415.70	42,750,415.20
110	Орлогын албан татвар		19,600,759.90	31,926,740.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		17,758,787.60	28,199,349.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-752,089.60	-1,008,998.10
1103	ААН-ын орлогын албан татвар		2,594,061.80	4,736,389.30
113	Хөрөнгийн албан татвар		2,687,633.30	2,755,264.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		6,534,022.50	8,068,410.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	88,904,081.00	110,002,807.20
120	Нийтлэг татварын бус орлого		51,234,915.30	53,078,512.60
121	Хөрөнгийн орлого		301,270.10	232,082.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		37,367,895.60	56,692,212.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		88,839,416.10	6,134,161.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	61,149,058.70	84,538,054.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		61,100,522.60	84,531,054.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		60,032,708.50	81,801,565.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		14,194,284.40	22,656,131.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,783,179.50	2,735,911.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,653,836.80	18,159,549.80
2104	Хангамж, бараа материалын зардал		1,705,261.20	2,241,033.70
2105	Нормативт зардал		783,449.70	848,499.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		799,545.60	2,214,041.50
2107	Томилолт, зочны зардал		538,248.60	743,571.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		21,001,388.70	10,372,889.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		17,573,514.10	21,829,936.50
212	ТАТААС		329,839.50	399,012.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		737,974.60	2,330,477.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		48,536.10	7,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		145,416,854.10	74,349,328.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		131,687,706.80	50,435,818.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		13,729,147.40	23,913,509.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,539,676.1	0.0	174,539,676.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	211,567.2	0.0	211,567.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,751,243.3	0.0	174,751,243.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-107,647.1	0.0	-107,647.1
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,478,709.8	0.0	2,478,709.8
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	-763,365.5	0.0	-763,365.5
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	13,729,147.4	0.0	13,729,147.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,088,087.9	0.0	190,088,087.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,088,087.9	0.0	190,088,087.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,091,851.8	0.0	-1,091,851.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	188,996,236.1	0.0	188,996,236.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,389.0	0.0	-2,389.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	43,398.0	0.0	43,398.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	-31,548.5	0.0	-31,548.5
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	23,913,509.9	0.0	23,913,509.9
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	212,919,206.5	0.0	212,919,206.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		183,313,139.00	131,828,372.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		29,954,691.20	42,750,415.20
110	Орлогын албан татвар		20,733,035.40	31,926,740.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		20,893,673.40	28,199,349.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-752,089.60	-1,008,998.10
1103	ААН-ын орлогын албан татвар		591,451.50	4,736,389.30
113	Хөрөнгийн албан татвар		2,687,633.30	2,755,264.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		6,534,022.50	8,068,410.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		1,204,508.50	1,536,286.60
1181	Газрын төлбөр		1,857,882.90	2,381,915.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		3,471,631.20	4,150,208.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		64,253,425.80	80,270,309.20
120	Нийтлэг татварын бус орлого		26,584,260.10	23,346,014.60
121	Хөрөнгийн орлого		301,270.10	232,082.40
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		37,367,895.60	56,692,212.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		89,105,022.00	8,807,647.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		65,394,856.30	85,300,528.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		65,394,856.30	85,300,528.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		64,300,682.70	82,525,680.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,101,487.30	25,289,945.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,377,439.60	3,666,618.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,578,535.50	19,442,350.40
2104	Хангамж, бараа материалын зардал		6,274,299.40	6,817,654.90
2105	Нормативт зардал		748,750.90	839,795.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		955,094.50	2,357,485.90
2107	Томилолт, зочны зардал		552,047.80	749,225.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,811,120.30	10,151,847.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,901,907.50	13,210,756.20
212	ТАТААС		341,339.50	399,012.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		752,834.10	2,375,836.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		117,918,282.60	46,527,843.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		549.5	338.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		109,671,648.40	35,404,126.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		109,671,648.40	35,404,126.70
2200	Дотоод эх үүсвэрээр		109,671,648.40	35,404,126.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-109,671,098.90	-35,403,788.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-1,940,028.00	-1,254,721.60
14	Бусад эх үүсвэр		320,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2,232,721.00	1,182,380.50
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		27,307.00	72,341.10
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		6,307,155.70	9,869,333.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,150,604.50	27,457,760.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		27,457,760.20	37,327,094.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар нэмэлт тодруулгуудад АОУС, Төрийн аудитын MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын горим сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 192,836.8 сая төгрөгийн 1 хувь буюу 1,928.4 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд материаллаг өөрчлөлт гарсан тул 2,474.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Аймгийн ЗДТГ-ын СТСХ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 708.4 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 163.7 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 164.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 138 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан бөгөөд үндсэн тайлан, байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар тодруулга гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 255,056.8 сая төгрөг болж, өмнөх оноос 12.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч				/сая төгрөгөөр/
Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	54,073.8	55,506.4	1,432.6	21.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	171,946.3	199,550.4	27,604.1	78.2
Нийт хөрөнгийн дүн	226,020.1	255,056.8	29,036.7	100.0
Нийт өр төлбөр	35,932.0	42,137.6	6,205.6	16.5
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	190,088.1	212,919.2	22,831.1	83.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн	226,020.1	255,056.8	29,036.7	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 29,036.7 сая төгрөгөөр өсөхөд Бэрх хөгжил ОНӨҮГ 6,218.9 сая төгрөг, Батширээт сумын ЗДТГ 1,180.3 сая төгрөг, Бэрх тосгоны ЗДТГ 2,246.8 сая төгрөг, Норовлин сумын ЗДТГ 1,082.5 сая төгрөг, Хэрлэн сумын ЗДТГ 4,498.4 сая төгрөг, Цэнхэрмандал сумын ЗДТГ 3,816.1 сая төгрөг, аймгийн ерөнхий орлогын данс 4,737.8 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 1,784.1 сая төгрөг, Хэрлэн сумын ерөнхий орлогын данс 2,068.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 23,913.5 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 378.7 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 12,521.4 сая төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн 23,227.9

сая төгрөгийн эерэг /орлого нь зардлаасаа их/ төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 12,214.5 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарсан байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 30,620.2 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 17,973.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2024 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 131,828.4 сая төгрөг, зарлага 85,300.6 сая төгрөг, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 46,527.8 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй илэрхийлсэн байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 37,327.1 сая төгрөг болж, өмнөх оноос 9,869.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касс байгаа бэлэн мөнгө	3.0	3.3	0.3	0.0
Банкинд байгаа бэлэн мөнгө	26,804.4	37,133.5	10,329.1	99.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	650.4	190.3	(460.1)	0.5
Дүн	27,457.8	37,327.1	9,869.3	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	713.0	1,259.3	546.3	3.4
Төрийн сан	9,888.3	21,584.2	11,695.9	57.8
Төсөвт байгууллага	4,642.0	6,694.4	2,052.4	17.9
Төсөл, сан	12,214.5	7,789.2	(4,425.3)	20.9
Дүн	27,457.8	37,327.1	9,869.3	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9,869.3 сая төгрөгөөр өсөхөд орон нутгийн өмчит хуулийн этгээд 546.3 сая төгрөг, төрийн сан 11,696.0 сая төгрөг, төсвийн байгууллага 2,052.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн 35,876.6 сая төгрөг буюу 96.6 хувь нь төрийн сан, 1,256.0 сая төгрөг буюу 3.4 хувь нь арилжааны банканд байршиж байна.

Арилжааны банканд байгаа мөнгөний 1,254.7 сая төгрөг буюу 99.9 хувь нь 21 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үлдэгдэл, 1.3 сая төгрөг төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн 4.2 сая төгрөг нь аймгийн төсвийн орлого, 186.1 сая төгрөг нь сумын төсвийн орлого байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 21,584.2 сая төгрөг болж, өмнөх оноос 11,696.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Хэнтий аймгийн ерөнхий орлого	1,099.0	6,545.1	5,446.2	30.3
Батноров сумын ерөнхий орлого	477.4	518.2	40.8	2.4
Батширээт сумын ерөнхий орлого	1,119.5	1,857.4	737.9	8.6
Баян-Адарга сумын ерөнхий орлого	97.1	380.4	283.3	1.8
Баянмөнх сумын ерөнхий орлого	283.6	574.7	291.1	2.7
Баян-Овоо сумын ерөнхий орлого	259.2	531.4	272.2	2.5
Баянхутаг сумын ерөнхий орлого	184.1	273.7	89.5	1.3
Биндэр сумын ерөнхий орлого	145.1	450.3	305.2	2.1
Бор-Өндөр сумын ерөнхий орлого	1,558.8	1,244.4	(314.5)	5.8
Бэрх сумын ерөнхий орлого	274.5	418.0	143.5	1.9
Галшар сумын ерөнхий орлого	186.6	349.6	163.0	1.6
Гурванбаян сумын ерөнхий орлого	51.3	122.3	71.0	0.6
Дадал сумын ерөнхий орлого	271.7	604.0	332.3	2.8
Дархан сумын ерөнхий орлого	168.6	422.9	254.3	2.0
Дэлгэрхаан сумын ерөнхий орлого	494.1	880.4	386.2	4.1
Жаргалтхаан сумын ерөнхий орлого	49.5	141.9	92.4	0.7
Мөрөн сумын ерөнхий орлого	509.0	533.7	24.6	2.5

Норовлин сумын ерөнхий орлого	116.4	362.9	246.5	1.7
Өлзийт сумын ерөнхий орлого	116.4	415.1	298.7	1.9
Өмнөдэлгэр сумын ерөнхий орлого	241.0	493.0	252.0	2.3
Хэрлэн сумын ерөнхий орлого	1,967.0	4,035.4	2,068.5	18.7
Хэрлэнбаян-Улаан сумын ерөнхий орлого	120.0	243.8	123.8	1.1
Цэнхэрмандал сумын ерөнхий орлого	98.3	185.7	87.4	0.9
Дүн	9,888.3	21,584.2	11,696.0	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн үлдэгдлийн дийлэнх хувийг аймгийн болон Батширээт, Хэрлэн сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл эзэлж байна.

Аймаг, сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл өсөхөд татварын болон татварын бус орлого 13,664.4 сая төгрөгөөр давж биелсэн, төсвийн байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 6,587.3 сая төгрөг төвлөрүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой нийт 426.5 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 426.5 мянган төгрөгийн 11 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1 зөрчилд албан шаардлага өгсөн байна. Үүнд:

Дадал сумын тохижилт ААТҮГ-т сумын 3.5 км хатуу хучилттай авто замын чанарын баталгааг чөлөөлүүлэх зорилгоор замыг зүгшрүүлэх хугацаанд гарсан эвдрэлийг засах ажлын зардлыг харилцах дансанд байршуулсан зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

4.2 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 7,464.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1,268.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Авлагын дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.1	20.3	18.2	0.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	127.8	130.3	2.4	1.7
Зээлийн хүүгийн авлага	36.1	19.6	(16.5)	0.3
Дансны авлага /ТӨҮГ/	219.7	297.7	78.0	4.0
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	43.2	0.1	(43.1)	0.0
Байгууллагаас авах авлага	820.1	1,115.4	295.3	14.9
Хувь хүмүүсээс авах авлага	1,590.3	355.0	(1,235.3)	4.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл	30.0	30.0	-	0.4
Хувь хүмүүст олгосон зээл	5,688.7	5,334.6	(354.1)	71.5
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	175.6	161.6	(14.0)	2.2
Дүн	8,733.5	7,464.6	(1,268.9)	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	1,781.6	844.2	(937.4)	11.3
Төрийн сан	30.0	30.0	-	0.4
Төсөвт байгууллага	6,647.4	6,315.9	(331.5)	84.6
Төсөл, сан	274.5	274.5	-	3.7
Нийт дүн	8,733.5	7,464.6	(1,268.9)	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлийн дийлэнх буюу 71.5 хувийг хувь хүмүүст олгосон зээл, 14.9 хувийг байгууллагаас авах авлага, 4.8 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 4.0 хувийг ОНӨҮГ-ын дансны авлага, 2.2 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл, 1.7 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага эзэлж байна.

Тайлант онд хувь хүмүүсээс авах авлага 1,235.3 сая төгрөгөөр, хувь хүмүүст олгосон зээл 354.1 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 43.1 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 16.5 сая төгрөг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл 14.0 сая төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 1,003.7 сая төгрөг, ОНӨҮГ-ын дансны авлага 78.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Байгууллагаас авах авлагын дансны үлдэгдэл өсөхөд Баян-Овоо, Өмнөдэлгэр сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийн 88.8 сая төгрөг, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд урьдчилж төлсөн 148.3 сая төгрөг, аймгийн өрхийн эмнэлгүүдийн ЭМДС-аас авах санхүүжилтийн авлага 76.0 сая төгрөг, Бор-Өндөр, Өмнөдэлгэр сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлээс төвлөрүүлсэн 590.7 сая төгрөг, аймгийн ИТХ-ын ном хэвлүүлэх зардалд урьдчилж төлсөн зардал 10.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хувь хүмүүсээс авах авлага буурахад Хэнтий орон сууц ОНӨҮГ-ын орон сууцны авлага 1,311.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Тайлант онд хувь хүмүүст олгосон зээл буюу хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 1,099.7 сая төгрөгөөр буурч, Батширээт, Дархан, Цэнхэрмандал, Хэрлэн суманд 598.7 сая төгрөгийн зээл олголтоор нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой нийт 841.5 сая төгрөгийн 28 алдаа, зөрчил илэрснээс 695.5 сая төгрөгийн 23 алдааг аудитын явцад залруулж, 145.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

-Бор-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Хэнтий шинэс сум дундын ойн анги, Хэнтий-Ус ХХК-ны нийт 145.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй;

-Галшар сумын ЗДТГ 0.3 сая төгрөгийн ажиллагсдаас авах авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй;

4.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 952.1 сая төгрөг болж, өмнөх оноос 466.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Урьдчилгаа дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	423.4	785.1	361.7	82.5
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	61.3	165.8	104.4	17.4
Цалингийн урьдчилгаа	1.2	1.3	0.1	0.1
Дүн	485.9	952.1	466.2	100.0
Үүнээс: байгууллагын төрлөөр			0.0	
ОНӨҮГ	2.8	1.1	-1.7	0.1
Төсөвт байгууллага	483.1	951.0	467.9	99.9
Дүн	485.9	952.1	466.2	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 68.4 хувийг төсөл сангийн, 31.4 хувийг төсөвт байгууллагын, 0.1 хувийг ОНӨҮГ-ын урьдчилгаа эзэлж байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өссөн нь Баян-Адарга, Батширээт, Гурванбаян, Дархан, Биндэр сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд урьдчилж төлсөн 466.2 сая төгрөгөөр нэмэгдсэн холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой нийт 298.7 сая төгрөгийн 10 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан байна.

4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл 9,315.5 сая төгрөг болж, өмнөх оноос 7,746.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Бараа материал данс ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	138.2	179.2	41.0	1.9
Эм боох материал	70.3	99.4	29.1	1.1
Дуусаагүй үйлдвэрлэл	-	37.0	37.0	0.4
Бэлэн бүтээгдэхүүн	1.6	1.7	0.1	0.0
Бичиг хэргийн материал	111.8	163.0	51.2	1.7
Аж ахуйн материал	2,318.1	3,116.0	797.9	33.4
Сэлбэг хэрэгсэл	121.2	159.0	37.8	1.7
Түлш, шатах тослох материал	139.2	44.1	(95.1)	0.5
Барилгын засварын материал	51.6	119.2	67.6	1.3
Хүнсний материал	0.9	0.3	(0.6)	0.0
Бусад хангамжийн материал	13,480.5	4,812.0	(8,668.5)	51.7
Биологийн хөрөнгө	13.0	17.7	4.7	0.2
Мал амьтад	615.8	566.9	(48.9)	6.1
	17,062.2	9,315.5	(7,746.7)	100.0
Үүнээс: байгууллагын төрлөөр			-	-
ОНӨҮГ	796.7	934.4	137.7	10.0
Төсөвт байгууллага	16,265.5	8,381.1	(7,884.4)	90.0
Дүн	17,062.2	9,315.5	(7,746.7)	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дийлэнх хувийг эзэлж байгаа бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 7,746.7 сая төгрөгөөр буурахад улсын төсвийн хөрөнгө оруулалтын дуусаагүй ажлын 12,083.2 сая төгрөгийг данснаас хассан нь нөлөөлжээ.

Бусад хангамжийн материал дансны үлдэгдэлд замын сангийн 557.2 сая төгрөгийн 2, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,934.0 сая төгрөгийн 13, орон нутгийн хөрөнгө оруулалтын 669.8 сая төгрөгийн 3 дуусаагүй төсөл арга хэмжээ бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой нийт 927.5 сая төгрөгийн 29 алдаа, зөрчил илэрснээс 189.1 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, 714.2 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 24.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Хэрлэн сумын ХХС, Баян-Адарга, Мөрөн, Хэрлэн сумын ЗДТГ нь нийт 381.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй;

Мөрөн сумын ИТХ, ЗДТГ, Цэнхэрмандал хөгжил ААТҮГ, Өндөрхаан хот тохижилт нь нийт 284.7 сая төгрөгийн бараа материалыг анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй;

Галшар сумын ИТХ, Хэнтий-Ус ХХК нь нийт 64.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас зөрүүтэй;

Баян-Овоо сумын ЗДТГ нь 7.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй үнээр худалдан авсан өвс, тэжээлийг материалын тайланд бүртгээгүй;

НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 244.0 сая төгрөг болж, өмнөх оноос 111.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нөөцийн бараа дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тэжээлийн нөөц	132.4	237.0	104.6	97.1
Шатахууны нөөц		7.0	7.0	2.9
Дүн	132.4	244.0	111.6	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	132.4	244.0	111.6	100.0
Дүн	132.4	244.0	111.6	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэлд 10 сумын ЗДТГ-ын 192.9 сая төгрөг, малын эрсдэлээс хамгаалах сангийн 44.1 сая төгрөгийн тэжээл, Хэрлэн сумын ЗДТГ-ын 7.0 сая төгрөгийн шатахууны нөөц байна.

4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 203.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Бусад эргэлтийн хөрөнгийн данс байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНӨҮГ	202.0	203.1	1.1	100.0
Дүн	202.0	203.1	1.1	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэлд Хэнтий орон сууц ОНӨҮГ-ын эзэмшилд байгаа борлуулах зорилготой орон сууцны зоорины давхрын байр бүртгэлтэй байна.

4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 199,550.3 сая төгрөг болж, өмнөх оноос 27,604.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №9. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	156,900.2	180,134.6	23,234.4	90.3
Биет бус хөрөнгө	15,046.1	19,415.7	4,369.6	9.7
Дүн	171,946.3	199,550.3	27,604.0	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	33,879.6	45,050.5	11,171.0	22.6
Төсөвт байгууллага	138,066.7	154,499.8	16,433.0	77.4
Дүн	171,946.3	199,550.3	27,604.0	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 27,604.0 сая төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж 20,151.8 сая төгрөг, авто тээврийн хэрэгсэл 2,996.4 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 1,434.9 сая төгрөг, зам, гүүрийн байгууламж 8,289.0 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 1,046.1 сая төгрөг, бусад биет бус хөрөнгө 4,386.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 180,134.6 сая төгрөг буюу 90.3 хувийг биет хөрөнгө, 19,415.7 сая төгрөг буюу 9.7 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө данстай холбоотой нийт 2,919.8 сая төгрөгийн 50 алдаа, зөрчил илэрснээс 2,782.1 сая төгрөгийн 44 алдааг аудитын явцад залруулж, 137.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.Үүнд:

Баянмөнх сумын ЗДТГ, Бэрх тосгоны ЗАА, Хэнтий-Ус ХХК нь үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй;

Орон нутгийн өмчийн газар, Хэрлэн сумын ЗДТГ нь нийт 131.0 сая төгрөгийн хөрөнгийг тоолоогүй, тооцоо бодоогүй;

Дархан сумын ИТХ 7.6 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар авсан;

4.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 42,846.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,914.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №10. Өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат зээлийн өглөг	293.3	221.8	(71.5)	0.5
Өглөг	14,519.7	10,061.7	(4,458.0)	23.5
Урьдчилж орсон орлого	8,339.9	20,141.5	11,801.6	47.0
Урт хугацаат өр төлбөр	12,779.1	12,421.0	(358.1)	29.0
Дүн	35,932.0	42,846.0	6,914.0	100.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	23,888.6	34,302.0	10,413.4	80.1
Төрийн сан	12,003.1	708.4	(11,294.7)	1.7
Төсөвт байгууллага	40.3	46.4	6.1	0.1
Төсөл, сан		7,789.2	7,789.2	18.2
Нийт дүн	35,932.0	42,846.0	6,914.0	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийн 47.0 хувийг урьдчилж орсон орлого, 29.0 хувийг урт хугацаат зээл, 23.5 хувийг бусад өглөг, 0.5 хувийг богино хугацаат зээл эзэлж байна.

Урьдчилж орсон орлогын үлдэгдэлд орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 20,141.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Уг хөрөнгийн 12,565.8 сая төгрөг буюу 62.4 хувийг Хэнтий-Ус ХХК, 6,157.7 сая төгрөг буюу 30.6 хувийг Бэрх хөгжил ОНӨҮГ-ын хөрөнгө эзэлж байна.

Богино хугацаат зээлийн үлдэгдлийн 221.8 сая төгрөг нь Хэнтий-Ус ХХК-ны ногоон зээлийн үлдэгдэл ба зээл хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөж байна.

Урт хугацаат өр төлбөрийн 12,421.0 сая төгрөгийн үлдэгдэл нь Хэнтий-Ус ХХК-ний МОН-1907 Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд 2003 онд авсан 1,975.2 сая төгрөг, МОН-3713 Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 2019 онд авсан 2.9 сая ам долларын зээл байна.

Тус зээлийн төлбөрт 2022 онд 799.6 сая төгрөг, 2023 онд 725.7 сая төгрөг, 2024 онд 536.2 сая төгрөг нийт 2,061.5 сая төгрөгийг төлсөн боловч төлбөр гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөхгүй байна.

Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийг хуваарийн дагуу хийхгүй байгаагаас өмнөх оны төлбөр хуримтлагдаж, валютын ханшийн зөрүү, хугацаа хэтрэлтийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

Иймээс зээлийн эргэн төлөгдөх дүнтэй уялдуулан зээлийг төлөвлөж, хуваарийн дагуу төлөх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөр данстай холбоотой нийт 6,878.7 сая төгрөгийн 12 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 212,919.2 сая төгрөг болж, өмнөх оноос 22,831.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №11. Засгийн газрын хувь оролцоо дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	32,546.2	32,579.6	33.4	15.3
Өмч /ОНӨҮГ/	2,006.9	2,022.1	15.2	0.9
Өмнөх үеийн үр дүн	126,399.4	138,999.5	12,600.1	65.3
Тайлант оны үр дүн	13,729.1	23,913.5	10,184.4	11.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,406.5	15,404.5	(2.0)	7.2
Дүн	190,088.1	212,919.2	22,831.1	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 266.5 сая төгрөг, төсөвт байгууллагын 11,551.3 сая төгрөг, төрийн сангийн 23,227.9 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөл сангийн 12,214.5 сая төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө нь Батширээт, Дадал сумын ЗДТГ-ын газрыг бүртгэсэнтэй холбоотой 33.4 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч Жаргалтхаан тохижилт үйлчилгээ, Баян-Адарга сумын Хатдын өргөө ОНӨҮГ-ын хөрөнгийн 15.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.9 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 22, орон нутгийн төсвийн 95, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 21 нийт 138 санхүүгийн тайланг аудитад хамруулж, 48 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 88 санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Дүгнэлт өгсөн байгууллагаас 30 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 17 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт №12. Өөрчлөлттэй санал дүгнэлт өгсөн байгууллагууд

Хязгаарлалттай санал дүгнэлт	
1. Баян-Адарга сумын Засаг дарга	10. Баян-Адарга сумын Засаг даргын тамгын газар
2. Баян-Овоо сумын Засаг дарга	11. Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газар
3. Биндэр сумын Засаг дарга	12. Галшар сумын Засаг даргын тамгын газар
4. Дадал сумын Засаг дарга	13. Дадал сумын Засаг даргын тамгын газар
5. Мөрөн сумын Засаг дарга	14. Жаргалтхаан сумын Засаг даргын тамгын газар
6. Өлзийт тосгоны Захирагч	15. Мөрөн сумын Засаг даргын тамгын газар
7. Өмнөдэлгэр сумын Засаг дарга	16. Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар
8. Хэрлэн сумын Засаг дарга	17. Хэнтий-Ус
9.Цэнхэрмандал сумын Засаг дарга	

Аудитаар нийт 16,781.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,119.3 сая төгрөгийн 137 алдааг аудитын явцад залруулж, 139.4 сая төгрөгийн зөрчилд 57 төлбөрийн акт тогтоож, 2,730.7 сая төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага, 791.9 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмжийг хүргүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд гарсан зөрчлийг нэгдсэн төсвийн гүйцэтгэл, нэгтгэсэн тайланд хамааруулан ангилсан.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Хэнтий аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн өмчит 21 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Үүнээс:

Хэнтий-Ус ХХК-ний санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт, Өндөрхаан хот тохижилтын газрын санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, бусад 19 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн өмчит байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,727.6 сая төгрөгийн 37 алдаа, зөрчил илэрснээс 7,419.9 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулж, 283.6 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 24.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт №13. Орон нутгийн өмчит байгууллагын хариуцлагын хэлбэр

№	Байгууллагын нэр	Хариуцлагын хэлбэр	Байгуулагдсан огноо
1	Хэнтий-Ус ХХК	ХХК	2005.11.14
2	Хэрлэн дом	ЗБН	2006.05.28
3	Оюуны шим	ЗБН	2006.06.10
4	Ач манал	ЗБН	2007.01.30
5	Өндөрхаан хот тохижилт	ОНӨААТҮГ	2008.06.16
6	Биндэр сум дундын ойн анги	ААТҮГ	2010.01.04
7	Батширээт ой анги	ТБАГУТҮГ	2010.01.14
8	Хэнтий шинэс сум дундын ойн анги	ОНӨААТҮГ	2010.04.05
9	Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн анги	ТӨААТҮГ	2013.10.10
10	Монгол хатдын өргөө цогцолбор	ААТҮГ	2013.12.04
11	Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ	ОНӨААТҮГ	2014.05.27
12	Биндэр нийтлэг үйлчилгээ	ОНӨААТҮГ	2014.09.03
13	Цэгцүүлэн дом	ЗБН	2016.04.04
14	Жаргалтхаан тохижилт үйлчилгээ	ОНӨААТҮГ	2017.12.04
15	Хэнтий аймгийн Дархан сумын тохижилт үйлчилгээ	ААТҮГ	2020.07.28
16	Баян-Адарга сумын Адарга тохижилт	ААТҮГ	2021.02.26
17	Хэнтий орон сууц	ААТҮГ	2021.04.14

18	Дэлгэрхаан сумын Аварга тохижилт	ААТҮГ	2021.05.13
19	Хэнтий аймгийн Бэрх хотын Бэрх хөгжил	ОНӨААТҮГ	2022.02.28
20	Цэнхэрмандал хөгжил	ААТҮГ	2022.10.28
21	Дадал тохижилт	ААТҮГ	2023.03.22

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 2024 онд 20,731.8 сая төгрөгийн орлого олж, 19,507.4 сая төгрөгийн зардал гаргаж, 1,224.4 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч 7 байгууллага 119.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт №14. Орон нутгийн өмчит байгууллагын ашиг, алдагдал /сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Орлого	Зардал	Цэвэр Ашиг/ алдагдал
1	Хэнтий-Ус ХХК	8,656.9	8,593.3	63.7
2	Хэрлэн дом	741.1	653.6	87.5
3	Оюуны шим	731.6	707.4	24.1
4	Ач манал	444.5	455.4	(10.9)
5	Өндөрхаан хот тохижилт	6,305.5	5,505.4	800.2
6	Биндэр ой сум дундын ойн анги	389.2	412.2	(23.0)
7	Батширээт ой анги	496.3	317.5	178.8
8	Хэнтий шинэс сум дундын ойн анги	127.5	86.7	40.7
9	Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ойн анги	108.3	119.7	(11.4)
10	Монгол хатдын өргөө цогцолбор	58.3	88.3	(30.1)
11	Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ	73.8	69.5	4.3
12	Биндэр нийтлэг үйлчилгээ	613.8	645.9	(32.1)
13	Цэгцүүлэн дом	637.3	613.2	24.1
14	Жаргалтхаан тохижилт үйлчилгээ	130.3	129.9	0.4
15	Хэнтий аймгийн Дархан сумын тохижилт үйлчилгээ	401.3	363.3	38.0
16	Баян-Адарга сумын Адарга тохижилт	43.7	44.4	(0.7)
17	Хэнтий орон сууц	118.9	118.2	0.8
18	Дэлгэрхаан сумын Аварга тохижилт	38.5	37.2	1.3
19	Хэнтий аймгийн Бэрх хотын Бэрх хөгжил	363.6	302.5	61.2
20	Цэнхэрмандал хөгжил	101.3	113.1	(11.8)
21	Дадал тохижилт	150.2	131.0	19.2
НИЙТ		20,731.8	19,507.4	1,224.4

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно” гэсний дагуу зохион байгуулагдсан аймгийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хариуцлагын болон санхүүжилтийн хэлбэр харилцан адилгүй байна. Тухайлбал:

Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдын ойн ангиуд ОНӨААТҮГ, ТӨХХТҮГ, ААТҮГ, ТБАГУТҮГ гэсэн 4 өөр хариуцлагын хэлбэртэй, Батширээт, Биндэр, Өмнөдэлгэр сумдын ойн ангиуд орон нутгийн төсөв болон өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжиж аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 санхүүгийн тайлан гарган нэгтгүүлдэг.

Хэрлэн, Баян-Адарга, Биндэр, Бэрх, Дадал, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдын тохижилт, үйлчилгээний газрууд ААТҮГ, ОНӨААТҮГ гэсэн 2 хариуцлагын хэлбэртэй, санхүүжилтийн хувьд Хэрлэн сумын Өндөрхаан тохижилт ОНӨААТҮГ орон нутгийн төсвөөс санхүүждэг, бусад өмчийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжиж байна.

Тайлант онд Ач манал ЗБН, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Адарга тохижилт, Биндэр ой сум дундын ойн анги, Монгол хатдын өргөө цогцолбор, Цэнхэрмандал хөгжил ААТҮГ, Цэнхэрмандал ойн анги ТӨААТҮГ-ууд нь 119.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үүнээс үзэхэд Өндөрхаан хот тохижилт, Биндэр ой сум дундын ойн анги, Хэнтий шинэс сум дундын ойн ангийн эд хөрөнгийн эрхийн байдал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1¹, 15.2²-т заасанд нийцэхгүй байна.

Хэнтий-Ус ХХК-аас бусад орон нутгийн өмчит хуулийн этгээд үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй, биелэлтийг тооцохгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан гэрээг байгуулаагүй, 20 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхгүй байна.

Иймд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг өөрийн орлогоор үйл ажиллагаагаа үр ашигтай явуулахад анхаарах, алдагдалтай ажиллаж байгаа хуулийн этгээдийг татан буулгах, хариуцлагын хэлбэрийг оновчтой тодорхойлох ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

4.11 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 10,566.7 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан. Үүнд:

- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны орлогын дансанд орон нутгийн өмчит 12 байгууллагын бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлогын 1,443.7 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого дансанд 583.0 сая төгрөг, бусад орлогын дансанд 706.7 сая төгрөгийг бүртгэсэн нь санхүүгийн тайлагналын ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Малын эрсдэлээс хамгаалах сангаас худалдан авсан хивэг, өвс, тэжээлийг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлагналын ангилал, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хөрөнгө оруулалтын барьцаа дансны өмнөх оны үлдэгдэл 12,003.1 сая төгрөгийн өглөгийг тайлант онд нийт дүнгээр бууруулан бүртгэж, тайлант онд үүссэн үлдэгдэл 7,789.2 сая төгрөгийн өглөгийг бүртгээгүй байна.

Аудитаар 381.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Малын эрсдэлийн сангаас хөнгөлөлттэй үнээр 78.5 сая төгрөгийн өвс, тэжээл худалдан авч 34.4 сая төгрөгийн хивгийг худалдан борлуулж, тайлант оны эцэст 44.1 сая төгрөгийн өвсний үлдэгдэлтэй байгаа ч тоолоогүй, тооллогын бүртгэл хөтлөөгүй;
- Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага 30.0 сая төгрөг, байгууллагаас авах авлага дансны орон сууцны сангийн зээлийн авлага 274.6 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн авлага 33.1 сая төгрөг нийт 337.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

¹ Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

² Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

4.9 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 30,398.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж хүргүүлснийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 15: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	4	30,398.4	4	30,398.4			100.0
Нийт	4	30,398.4	4	30,398.4			100.0

4. 10 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10 сумдын боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын 42 байгууллагад, Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу аймгийн Татварын газарт, Засаг даргын харьяаны 37 байгууллагын 2022, 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж, санхүүгийн эрсдэлийн түвшнийг тодорхойлжээ.

Аймгийн Засаг даргын 2024.06.18-ны өдрийн 37/04/27 дугаартай удирдамжийн дагуу аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийн хэрэгжилтэд дотоод аудитыг хийж, заасан хугацаанд холбогдох танилцуулга, тайлан дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Тайлант онд нийт 78 байгууллагад хяналт шалгалт, дотоод аудит хийж 391.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 384.3 сая төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага, 6.7 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн актыг тогтоож хэрэгжилтийг ханган ажилласан боловч Аудитын хороогоор хэлэлцүүлж, шийдвэрлэсэн дүгнэлт, тайлан гараагүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хяналт шалгалт, дотоод аудитыг тайлант хугацаанд хийж, эрсдэлийг удирдаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Аудитаар нийт 16,781.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,119.3 сая төгрөг буюу 78.2 хувь нь нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа эзэлж байна.
2. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тайлант хугацааны үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийг удирдаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахгүй байна.
3. Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг орон сууцны сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, аймгийн ерөнхий орлогын дансанд олон жилийн насжилттай, найдваргүй авлага үүссэн байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжиж байгаа дуусаагүй болон он дамжин хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн ажлыг данс бүртгэлд тусгахгүй орхигдуулах эрсдэлтэй байна.
5. Дамжуулан зээлдүүлэх гэрээний урт хугацаат зээлийг гэрээнд заасан хугацаанд төлөхгүй байгаагаас алданги, валютын ханшны өөрчлөлтөөс хуримтлагдсан төлбөр үүсэх эрсдэлтэй байна.
6. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын эд хөрөнгийн эрх, өөрийгөө санхүүжүүлэх эх үүсвэр харилцан адилгүй ба тайлант онд 7 байгууллага 119.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

1. Урт хугацаат зээлийн төлбөрийг графикийн дагуу шаардагдах хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөж, зээлийг хугацаанд нь төлөх.
2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх, хариуцлагын хэлбэрийг оновчтой тодорхойлон холбогдох ажлыг зохион байгуулах.
3. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааг чиглүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллах.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 04 дугаар сарын 22

Дугаар А/19

Чингис хот

Аудитын тайлан
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. “Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг аудитор (Б.Ариунаа)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэнтий аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Б.Ариунаа)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232501019

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын *0.4* оны
дүгээр сарын *22*-ны өдрийн *1/2* дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

2317144297
СЮА0046 9074082

**Хэнтий аймгийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн
аудитаар хүргүүлсэн албан шаардлагын жагсаалт**

№	Байгууллагын нэр	Аудитын код	Төлбөрийн актын дугаар	Дүн /төгрөг/
1	Хэнтий аймгийн Засаг дарга	ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ	183/ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ/А2370448	44,075,000.0
2	Хэнтий аймгийн Засаг дарга	ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ	184/ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ/А2370449	337,637,271.0
	ДҮН			381,712,271.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 дугаар сарын 18

Дугаар 183-ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ
А2370448 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын эрсдэлийн сангаас хөнгөлөлттэй үнээр 78.5 сая төгрөгийн өвс, тэжээл худалдан авч 34.4 сая төгрөгийн хивгийг худалдан борлуулж, тайлант оны эцэст 44.1 сая төгрөгийн өвсний үлдэгдэлтэй байгаа ч тоолж, тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Д.Аюурбунь, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

2317144397

232504183



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 дугаар сарын 18

Дугаар 184-ХЭА-2025/001/НА-СТА-ТЕЗ
А2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага 30.0 сая төгрөг, орон сууцны сангийн зээлийн авлага 274.6 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн авлага 33.1 сая төгрөг нийт 337.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Зээлийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Д.Аюурбунь, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



232504184